



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 243

Улаанбаатар хот


Г “Даваанбулаг” ХК-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Баянгол дүүргийн шүүхийн 2007 оны 155 дугаар шийдвэрийг, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны үнэт цаасны бүртгэлийн журмын 20 дугаар зүйлийг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

- “Даваанбулаг” ХК-ийн нийт гаргасан 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 91,550 /ерэн нэгэн мянга таван зуун тавь/ ширхэг энгийн хувьцаанаас 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 69,066 /жаран есөн мянга жаран зургаан/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасч, тус хувьцаат компанийн гаргасан нийт энгийн хувьцааг 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 22,484 /хорин хоёр мянга дөрвөн зуун наян дөрөв/ ширхэгээр тогтоосугай.
- Тогтоолын 1 дэх заалтын дагуу 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 69,066 ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.
- Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан улсын бүртгэлд өөрчлөлт оруулж ажиллахыг “Даваанбулаг” ХК /С.Мөнхбат/-д үүрэг болгосугай.
- Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



00283